

## ОЛОН УЛС СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭНГИЙН ДЭРГЭД ВЬЕТНАМ СУДЛАЛЫН ТӨВ БАЙГУУЛАГДАВ

ШУА-ийн Ерөнхийлөгч Б.Энхтүвшин тэргүүтэй төлөөлөгчид БНСВУ-ийн Нийгмийн ШУА-д айлчлах үеэр хоёр академийн удирдлага Монгол Улсад “Вьетнам судлалын төв”, БНСВУ-д “Монгол судлалын төв”-ийг харилцан байгуулахаар тохиролцсон билээ. Энэхүү тохиролцоог ажил хэрэг болгох, мөн Вьетнам судлалыг бүх талаар хөгжүүлэх, Монгол-Вьетнамын харилцааг өргөжүүлэн хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах зорилготойгоор Олон улс судлалын хүрээлэнгийн дэргэд “Вьетнам судлалын төв” Төрийн бус байгууллага 2012 оны 12-р сарын 28-ны өдөр байгуулагдав. Төвийг үүсгэн байгуулах хуралд манай улсын ШУА-ийн удирдлагууд, БНСВУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Хуанг Дуан Тхинь /Hoang Tuan Thinh/, Монгол Улсаас БНСВУ-д 2008-2012 онд сууж байсан элчин сайд П.Сүндэв, Монголын вьетнам судлалын эрдэмтэн судлаачид, их сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэн, найрамдлын нийгэмлэг, бизнесийн болон оюутны төлөөлөл оролцлоо.

Монгол-Вьетнамын эрдэм шинжилгээний байгууллагуудын хамтын ажиллагаа өнгөрсөн 2012 оноос эрс идэхижиж олон чиглэлээр өргөн хүрээнд хамтран ажиллаж эхэлсэн бөгөөд “Вьетнам судлалын төв”-ийг Монголд байгуулах болсон явдал энэ үйл явдалтай шууд холбоотой юм.

Манай хоёр орны түүхэн уламжлалт, ах дүүгийн найрсаг харилцаатай. 1954 оны 11 сарын 17-нд манай улс БНСВУ-тай албан ёсоор дипломат харилцаа тогтоосон. Хэдийгээр хоёр орны харилцаа хэсэг хугацаанд зогсонги байдалтай байсан боловч сүүлийн үед бүх салбарт харилцаа эргэн сэргэж байгаа энэ үед шинжлэх ухааны байгууллагуудын хооронд хамтын ажиллагааны эх тавигдсан нь манай хоёр орны хөгжил дэвшилд асар их ач холбогдолтой зүйл болж байна. Энэ ажилд ШУА-ийн удирдлагууд, эрдэмтэн судлаачдын санаачлан байгуулсан “Вьетнам судлалын төв” хэмээх энэхүү олон нийтийн байгууллага нь ихээхэн түлхэц үзүүлэх нь дамжиггүй.

“Вьетнам судлалын төв”-ийг байгуулах болсон бас нэг чухал шалтгаан бол дэлхий дахинаа Вьетнам орныг сонирхон судлах ажил маш эрчимтэй өрнөж байгаа явдал юм. Үүний илрэл нь 2012 оны 11 сарын 26-28-нд зохион байгуулагдсан “Вьетнам судлалын олон улсын 4-р хурал”. “Вьетнам судлалын төв” байгуулагдсанаар манай хоёр орны ард түмэн бие биенийхээ өнгөрсөн болон өнөөгийн байдлын талаар бодит ойлголт олж авах, улс орныхоо хөгжлийн арвин туршлагаас харилцан суралцах, туршлага солилцох, Монгол, Вьетнамын шинжлэх ухаан, боловсрол, худалдаа, эдийн засгийн харилцааг шинэ шатанд аваачихад чухал хувь нэмэр оруулах болно гэж төвийг үүсгэн байгуулагчид онцоллоо.

Мэдээ бэлтгэсэн Б.Цэнгэлхам